

БНСУ-ЫН ILWOO САНГИЙН ТЭТГЭЛЭГ

Хөтөлбөрийн товч танилцуулга

Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос улс хоорондын найрамдалт харилцаа, боловсрол, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаанд хувь нэмрээ оруулах, Монгол улсад шинэ залуу боловсон хүчин бэлтгэх зорилгоор БНСУ-ын ILWOO сангийн тэтгэлгээр суралцуулах сонгон шалгаруулалт явагдаж байна. Нийт элсүүлэх оюутны тоо 8

Тэтгэлгийн хэмжээ

Онгоцны тийз (анх явахад 1удаа, төгсөөд буцаж ирэхэд 1 удаа), оюутнуудын сургалтын болон оюутны дотуур байрны төлбөр, эрүүл мэндийн даатгалын төлбөрийг хариуцаж, сар бүр амьжиргааны тэтгэлэг олгох ба тэтгэлгийн хугацаа 4 жил, байна.

Шалгуур үзүүлэлт

- **Бакалаврын хөтөлбөр(Хугацаа: 3-4 дүгээр сар)**

Тэтгэлгийн хугацаа	Бакалаврын зэрэг	5 жилийн хугацаатай сургалт
Шалгуур үзүүлэлт	Сонгон шалгаруулалтанд оролцох хүн нь доор бичсэн шалгууруудыг хангах ёстой; <ol style="list-style-type: none">1. Өргөдөл гаргагч нь 17-21 нас хүртэлх Монгол улсын иргэн байх2. Өмнө нь аль нэг улсын Засгийн газрын тэтгэлэгт хамрагдаагүй байх3. Бүрэн дунд боловсролын гэрчилгээний дундаж үнэлгээний голч дүн 80-аас дээш, их дээд сургуулийн 1-2-р курст суралцдаг бол голч дүн 3,0 ба түүнээс дээш байх4. Нийгмийн чиглэлээр 4 оюутан, Инженерийн чиглэлээр 4 оюутан тус тус элсүүлнэ.	

Сонгон шалгаруулалтын үйл явц

1



Цахим өргөдөл
(www.esis.edu.mn/grant холбоосоор
хандаж цахим
өргөдөл бөглөн,
дараах баримт
бичгийг өргөдөлд
татаж оруулна)

2



Сонгон
шалгаруулалтыг
бичгийн шалгалт
болон ярилцлага
гэсэн үе шаттай
зохион байгуулна.
Бичгийн шалгалтад 60
ба түүнээс дээш оноо
авсан шалгуулагчдыг
ярилцлагад
оруулахаар нэр
дэвшүүлэх ба нэр
дэвшигчдийн
бүрдүүлсэн
материалыг ILWOO
санд хүргүүлнэ .

3



ILWOO сангаас
ярилцлагад орох
оюутнуудын нэрс
болон ярилцлага хийх
байр, цагийн хуваарийг
Боловсрол, соёл,
шинжлэх ухаан,
спортын яамны цахим
хуудасны нүүр хуудсан
дахь "гадаадад
суралцах" цэсэнд
байршуулна.
Ярилцлагыг ILWOO
сангаас хариуцан
зохион байгуулах ба
ярилцлагын дүнг
тухайн өдрөө
мэдээлнэ.



Ярилцлагад тэнцсэн
оюутнууд Улаанбаатар
хотод солонгос хэлний
сургалтад хамрагдана.
Сургалтад
хамрагдагчдаас
солонгос хэлний
төвшин тогтоох
шалгалт авч,
амжилттай дүн
үзүүлсэн оюутнуудыг
БНСУ-ын их, дээд
сургуульд
суралцуулна..

Дэлгэрэнгүй мэдээллийг авах бол

- БСШУСЯ-ны www.mecs.gov.mn сайтын гадаадад суралцах хэсгээс авна уу.